

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**  
(2017 оны жилийн эцсийн байдлаар)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2018-01-17

Улаанбаатар хот

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Хүрсэн түвшин, хэрэгжилт, хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО</b>						
<b>Зорилт 15. Хууль сахиулах үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгоно.</b>						
15.7	МУТХУБ-ын 2.4, Зорилт 1, 2,  ЗГҮАХ-ийн 5.2.2 дахь дэд заалт	<b>Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ:</b>  Худалдан авах ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгож, цахим хэлбэрээр зохион байгуулах  <b>Үйл ажиллагаа:</b> 15.7.1. Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох 15.7.2. Төсвийн урсгал зардлаар санхүүждэг байнгын хэрэгцээт бараа,	Нийт худалдан авалтад цахим худалдан авалтын эзлэх хувь	60.0	200.0 сая төгрөг,  Дэлхийн банкны санхүүжилтээр	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015-2016 онд гүйцэтгэсэн “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> –ийг 2017 онд бүрэн ашиглалтад оруулсан. “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн ашиглалтын талаарх улсын хэмжээний тоон үзүүлэлтийг дор танилцуулав:  2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд төрийн өмчит нийт 1133 хуулийн этгээд уг системд захиалагч байгууллагаар бүртгүүлсэн бөгөөд 2017 онд зохион байгуулах 10074 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн мэдээллийг нийтэлж, олон нийтэд ил тод мэдээлсэн. Эдгээрээс 3136 төсөл, арга хэмжээ нь шууд худалдан авах ажиллагаанд хамаарах буюу төсөвт өртөг нь 10.0 сая төгрөгөөс бага болно. 2017 онд захиалагч байгууллагуудаас нийт 4567 тендерийн урилгыг тус системд нээлттэй зарлаж, ил тод мэдээлснээс 2144 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан нь нийт зарлагдсан тендер шалгаруулалтын 47.0 хувийг эзэлж байна. Түүнчлэн, 3091 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн байна.

		<p>бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээгээр худалдан авах журам, зааврыг боловсронгуй болгож, худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p> <p>15.7.3. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч, худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</p> <p>15.7.4. Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн сургалтыг улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах</p>			<p>Сангийн яам, Монголбанк, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банктай тендерт оролцогчийн талаарх шаардлагатай мэдээллийг шуурхай солилцох боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах ажлын хүрээнд “цахим гарын үсэг”-ийг худалдан авах ажиллагаанд нэвтрүүлж, үндэсний тоон гарын үсгийн дэд бүтэцтэй холбогдсон. Монгол Улсад тоон гарын үсэг ашиглаж эхэлсэн төрийн байгууллагын анхны цахим систем <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> болсон.</p> <p>2017 онд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын шалгалтыг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> -ээр авч, нийт 8095 төрийн албан хаагч, иргэн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсанаас шалгалтад тэнцсэн 4576 иргэнд гэрчилгээ олгосон. Уг системийн бүртгэл-мэдээллийн санд нийт 10019 хүн бүртгэлтэй байна. Эдгээр бүртгэлтэй иргэнээс худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд томилж байгаа бөгөөд төрийн бус байгууллагын төлөөллийг санамсаргүй сонголтын аргаар сонгон томилж, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгон ажиллав.</p> <p>15.7.1. Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд дор дурдсан ажлуудыг тайлант хугацаанд гүйцэтгэв:</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 28 дугаар захирамжаар байгуулагдсан Шилэн тендерийн хуулийн төсөл боловсруулах асуудлыг судлах, хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн хүрээнд Сангийн сайдын 2017 оны 176 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг, мөн Сангийн яамнаас байгуулагдсан Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, түүний тендерийн жишиг баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ТӨБЗГ-ын</p>
--	--	--	--	--	---

					<p>төлөөлөл тус тус томилогдон ажиллаж, холбогдох судалгаа, шинжилгээ хийхэд оролцож, саналаа тусгасан.</p> <p>Тайлант онд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дараах журам, жишиг баримт бичгийн төсөлд тусгах санал боловсруулан, Сангийн яаманд хүргүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл;</li> <li>- Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний тендерийн жишиг баримт бичгийн төсөл;</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын төсөл;</li> <li>- Цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулах журмын төсөл;</li> <li>- Худалдан авах ажиллагааны урилга, үр дүнг зарлан мэдээлэх журмын төсөл.</li> </ul> <p>Эдгээрээс “Ерөнхий гэрээ байгуулах журам” нь Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” нь Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэгдэн тус тус батлагдсан.</p> <p>15.7.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын төсөл, түүний тендерийн жишиг баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий Сангийн яамнаас байгуулагдсан ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан бөгөөд Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар “Ерөнхий гэрээ байгуулах журам” батлагдсан. 2017 оны 12 сарын 22-ны өдөр “Ерөнхий нэршлийн зарим эмийг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” тендерийг зарласан бөгөөд уг тендер шалгаруулалтаар 17 нэр төрлийн эмийг “Ерөнхий гэрээ байгуулах журам”-аар зохион байгуулахаар Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллаж байна.</p> <p>15.7.3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад анхаарч, төрийн өмчит 87 компани, үйлдвэрийн газрыг цахим системд захиалагчаар бүртгэн, цахим хэлбэрээр тендер зарлах, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаар 2 удаагийн</p>
--	--	--	--	--	--

					<p>чиглэл өгөх тухай албан бичгийг харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэн, зөвлөмж, чиглэл, удирдамжаар хангаж ажиллав.</p> <p>2017 онд төрийн өмчит хуулийн этгээд нь нийт 3289 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэн 997 тендер зарлаж, 654 тендерийн үр дүнг цахим системд нийтэлсэн. Төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын цахим системийн хэрэглээ ахисан дүнтэй байна. Нийт зарласан тендерийн 310 буюу 30.0 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.</p> <p>“Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” <a href="https://tender.gov.mn">https://tender.gov.mn</a> -д бүртгэлтэй 1133 захиалагч байгууллага, 6025 гүйцэтгэгч, нийлүүлэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл, түүнчлэн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрх бүхий гэрчилгээтэй гишүүд, цахим системийн хэрэглэгчдэд зориулсан зааварчилга, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэгийг байнга үзүүлж, 2017 онд улсын хэмжээнд нийт 147 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 3152 хүнийг хамруулан чадавхижуулсан байна.</p> <p>Мөн иргэд олон нийтэд шуурхай мэдээлэл хүргэх, цаг алдалгүй зөвлөгөө өгөх зорилгоор OnlineHelpDesk-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллав.</p> <p>15.7.4. Дэлхийн банкны “Монгол, Вьетнам улсын худалдан авах ажиллагааны статистикийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн чадавхийг сайжруулах сургалт”-ыг улсын хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулав. Уг сургалтыг Дэлхийн банкны 200.0 сая төгрөгийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хамтран зохион байгуулж дуусав. Уг сургалтад УИХ-ын харьяа байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, худалдан авах ажиллагааны салбарын нийслэл дэх нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд зэрэг 208 байгууллага болон 21 аймаг дахь худалдан авах ажиллагааны захиалагч, нийлүүлэгч талын нийт 1050 төлөөллийг хамруулсан. Энэхүү сургалтын зэрэгцээ орон нутагт худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшүүлэх сургалтыг Сангийн яамтай хамтран зохион байгуулж, гэрчилгээ олгон худалдан авах ажиллагааны чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>
--	--	--	--	--	---

						<p><b>Өөрийн үнэлгээ:</b> “Тодорхой үр дүнд хүрсэн” – 70%</p> <p><b>Тэмдэглэл:</b> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй боловч тодорхой үр дүн гарсан, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай. Цаашид 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан. МУ-ын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан.</p>
15.8	<p>МУТХҮБ-ын 2.4, Зорилт 1, 2,</p> <p>ЗГҮАХ-ийн 5.2.1, 5.2.3 дахь дэд заалт</p>	<p><b>Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээ:</b></p> <p><b>Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх</b></p> <p><b>Үйл ажиллагаа:</b></p> <p>15.8.1. Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох</p> <p>15.8.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн талаар 2016-2020 онд баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж батлах</p> <p>15.8.3. Төрийн өмчит хуулийн этгээдийг 2017 онд өөрчлөн байгуулах, хувьчлах жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангах</p> <p>15.8.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	100.0	-	<p>15.8.1. Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-аас тодорхой арга хэмжээ авч ажилласан. Үүнд:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 126 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн :</p> <ul style="list-style-type: none"> <li>– Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;</li> <li>– “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл;</li> <li>– “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” УИХ-ын тогтоолын төсөл.</li> </ul> <p>2. ТӨБЗГ-ын хуралдааны тогтоолоор дараах журам, шийдвэрийг баталж, төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зарим зохицуулалтыг тодорхой болгон мөрдүүлэв:</p> <ul style="list-style-type: none"> <li>– ТӨБЗГ-ын 2017 оны 90 дугаар тогтоолоор “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”;</li> <li>– ТӨБЗГ-ын 2017 оны 67 дугаар тогтоолоор “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”;</li> <li>– “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай” ТӨБЗГ-ын 2017 оны 53 дугаар тогтоол батлагдаж, төрийн өөрийн өмчийн түрээсийн асуудлын зохицуулалтыг тодорхой болгов;</li> </ul>

		<p>оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, эрсдэлийн үнэлгээ, дотоод аудитын тайлангууд, Төлөөлөн удирдах зөвлөл болон хороодын тайланг үнэлж, дүгнэн хариуцлагын тогтолцоог тодорхой болгох</p> <p>15.8.5. Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>15.8.6. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авч, хяналт тавих</p>				<ul style="list-style-type: none"> <li>- ТӨБЗГ-ын 2017 оны 86 дугаар тогтоолоор “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;</li> <li>- ТӨБЗГ-ын 2017 оны 276 дугаар тогтоолоор “Төрийн өөрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”.</li> </ul> <p>15.8.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулахаар төлөвлөж байгаа бөгөөд “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д төрийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах тухай асуудлыг тусгасан.</p> <p>15.8.3. “2017 онд хувьчлах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төслийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. УИХ-ын гишүүн Я.Содбаатарын ахалсан Ажлын хэсэг 2017 оны 05 дугаар сард ТӨБЗГ-т ажиллахдаа өгсөн чиглэлийн дагуу “Төрийн өмчийг 2017-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн үзэл баримтлал, УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Холбогдох сайд нарын саналыг тусган 2018 онд Засгийн газрын хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Эдгээр төслүүд батлагдах хүртэлх хугацаанд УИХ-ын 2015 онд баталсан “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг УИХ-ын 2016 оны 64 дүгээр тогтоолд заасны дагуу үргэлжлүүлж байна.</p> <p>15.8.4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 45 компанийн 32 Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэд хороод, дотоод аудитын тайлан, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны тайланг хэлэлцэн дүгнэж, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэв. Захирлын гэрээг цуцалсан тохиолдол гараагүй байна. ТӨБЗГ-ын 2017 оны 90 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу гэрээг үнэлж дүгнэн, цаашид эдийн засгийн үр ашиг, ашигт ажиллагааг дээшлүүлэх, өр авлагыг бууруулах, санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудитын 2015-2016 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч,</p>
--	--	---	--	--	--	--

					<p>хэмнэлтийн горимд ажиллах үүрэг чиглэлийг гүйцэтгэх удирдлагуудад өгч, үр дүнг тооцох шийдвэр гаргасан. Эрчим хүчний 21 компани нь компанийн засаглал, эрдэлийн үнэлгээ, дотоод аудитын тайланг гаргаж хэвшсэн. Компанийн засаглалыг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх талаар “Компанийн засаглалын үндэсний төв” ТББ-тай хамтран 3 удаагийн чадавхижуулах сургалтыг тайлант хугацаанд зохион байгуулав.</p> <p>Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилт, ТӨБЗГ-аас компанийн ТУЗ-д өгсөн албан даалгавар, удирдамж, чиглэлийн биелэлтэд хяналт тавьж байна. ТУЗ-ийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд чөлөөлж, холбогдох хууль, журмын дагуу шинээр сонгон шалгаруулж, томилох чиглэл баримтлан үр дүнг тооцож байна. Тайлант хугацаанд, дурдсан журам, үүрэг, чиглэлийг хангалтгүй биелүүлсэн төрийн өмчит 4 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 гишүүнийг чөлөөлж, хариуцлага тооцсон.</p> <p>2017 онд төрийн өмчит компанийн хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулж, шинэчлэн томилох ажлыг зохион байгуулав. Нэг иргэнийг нэг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилох чиглэл барьж, ТУЗ-ийн хараат бус гишүүдээс тавих олон нийтийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх, Аудитын хорооны үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авсан. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг чадавхижуулах сургалтыг “Компанийн засаглалын үндэсний төв” ТББ-тай хамтран 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 92 хараат бус гишүүнийг хамруулав.</p> <p>15.8.5. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 2016 оны 41 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, ТӨБЗГ-аас “Албан даалгавар” гарган зарцуулагдаагүй цалин, хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд, хогшил, эхлээгүй ажил үйлчилгээний зардлуудыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулав. Үүний үр дүнд 2016 онд эдгээр тэвчиж болохуйц хөрөнгө оруулалтын зардлаас 32.7 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.</p>
--	--	--	--	--	---

					<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлахдаа үргүй зардлыг багасгах, бодит хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалт хийх, ашиг орлогыг нэмэгдүүлэх, авлага, өглөгийг бууруулах зарчим баримталж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, Монгол Улсын Засгийн газрын бодлого, чиглэлийг хэрэгжүүлэн ажилласан. Үүний үр дүнд, ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 72 хуулийн этгээдийн эдийн засгийн үзүүлэлт 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сайжирсан төлөвтэй байна. Тухайлбал, борлуулалтын орлого 2016 онд 1,555.1 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,797.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар буюу 242.8 тэрбум төгрөгөөр, цэвэр ашиг 2016 онд 1,105.2 сая төгрөгийн алдагдалтай байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,442.7 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 3 дахин буюу 4,547.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн дүнтэй байна.</p> <p>Нийт авлага 2016 онд 434.7 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 312.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 28.2 хувиар буюу 122.5 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 2016 онд 1,241.2 тэрбум төгрөг байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,201.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 3.2 хувь буюу 39.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан дүнтэй байна.</p> <p>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 13 компани, Төрийн банк, Хөгжлийн банкны дүн ороогүй болно.</p> <p>Мөн урт хугацаат өр төлбөрийн дүнд 9 хуулийн этгээдийн Хөгжлийн банкинд төлөх 1,054.6 тэрбум төгрөгийн өр төлбөр орсон бөгөөд нийт өр төлбөрийн 29.8 хувийг эзэлж байна.</p> <p>2016 онд төрийн өмчит 38 хуулийн этгээд ашигтай ажиллаж байсан бол 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 54 компани цэвэр ашигтай ажилласан, алдагдалтай ажилласан хуулийн этгээд 18 болж 2016 оныхоос 16-аар буурсан байна.</p> <p>2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бол 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин өссөн.</p>
--	--	--	--	--	---



					<p>Мөн өмч хувьчлалын орлого 16.8 тэрбум төгрөг, түрээсийн орлого 2.1 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлэв.</p> <p>15.8.6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд ТӨБЗГ-аас төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж ажилласан нийт 72 хуулийн этгээдийн 2016 оны жилийн эцсийн тайлан тэнцлийн дүн болон 2011-2016 оны үр ашгийн үзүүлэлтийг нэгтгэн товхимол боловсруулан гаргаж, УИХ-ын Байнгын хороо, Сангийн яам болон холбогдох байгууллагын ажлын хэрэгцээнд хүргүүлсэн болно.</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 100 хуулийн этгээдийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд 2 удаа аудит хийж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ТӨБЗГ-аас зөвлөмж, чиглэл өгөв.</p> <p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан 2016 оны гэрээг дүгнэхэд мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдлыг харгалзан дүгнэсэн, 2017 оны контрактыг 2018 оны эхний улиралд дүгнэнэ.</p> <p><b><u>Өөрийн үнэлгээ:</u> “Бүрэн хэрэгжсэн” – 100%</b></p> <p><b><u>Тэмдэглэл:</u> Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн гэж үзэх үндэстэй, ТӨБЗГ-аас гүйцэтгэвэл зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, үр дүн гарсан.</b></p>
--	--	--	--	--	---

Үнэлгээний дүнгийн танилцуулга:

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний тоо – 2;

Үүнээс:

- “Үр дүнтэй” буюу 100 % - 1 зорилт, арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 % - 1 зорилт, арга хэмжээ;
- Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ (хувь) – **85.0 %**.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ХЯНАСАН:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДЭД ДАРГА А.ДАГВАДОРЖ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

ТАЙЛАНГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ